



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын хүүхдийн 8-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/120/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Архангай аймаг  
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа  
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар  
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Цэцэгдулам  
Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитындүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.9 Завсрын аудитын үр дүн .....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БШУЯ	Боловсрол Шинжлэх ухааны яам
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

Ауд. 07.25 № 114  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН  
8-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ж.ЭНХСҮРЭН ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 8-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 8-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,731,543.72	27,485,580.80
35	БАРАА МАТЕРИАЛ	29,731,543.72	27,485,580.80
35400	Хангамжийн материал	29,731,543.72	27,485,580.80
35420	Аж ахуйн материал	28,771,543.72	27,432,630.80
35440	Түлш, шатах тослох материал	960,000.00	0.00
35460	Хүнсний материал	0.00	52,950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	406,595,868.00	398,412,177.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	406,595,868.00	398,412,177.00
39200	Биет хөрөнгө	375,806,493.00	367,785,927.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	346,372,982.44	346,372,982.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-10,196,460.18	-20,546,252.46
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	44,688,992.65	49,428,282.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19,399,368.88	-20,828,838.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,519,610.30	33,817,812.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,498,489.31	-22,574,161.14
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,750,000.00	0.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,546,874.82	0.00
39217	Ном	2,116,100.80	2,116,100.80
39300	Биет бус хөрөнгө	30,789,375.00	30,626,250.00
39301	Програм хангамж	2,117,500.00	2,117,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-778,125.00	-941,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	29,450,000.00	29,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	436,327,411.72	425,897,757.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	436,327,411.72	425,897,757.80
51	Засгийн газрын хувь оролцоо	436,327,411.72	425,897,757.80
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	356,921,047.43	356,921,047.43
51200	Хуримтлагдсан үр дүн	-8,336,380.72	-18,766,034.64
51210	Өмнөх үеийн үр дүн	-8,336,380.72	-8,336,380.72
51220	Тайлант үеийн үр дүн		-10,429,653.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	87,742,745.01	87,742,745.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	436,327,411.72	425,897,757.80

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	410,726,100.00	430,669,292.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,635,300.00	5,348,092.98
120	Нийтлэг татварын бус орлого	17,635,300.00	5,348,092.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,635,300.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,635,300.00	0.00
120009	Бусад орлого	0.00	568,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	4,779,892.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	393,090,800.00	425,321,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	367,291,600.00	398,966,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,291,600.00	398,966,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	845,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00	393.200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	245,000.00	175.000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,954,200.00	26,354,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,954,200.00	26,354,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	423,610,728.70	440,239,571.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,610,728.70	440,239,571.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	423,397,327.06	436,981,456.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,845,500.00	292,408,200.00
210101	Үндсэн цалин	196,317,214.94	214,548,179.00
210102	Нэмэгдэл	54,893,804.11	43,302,884.00
210104	Урамшуулал	23,634,480.95	34,557,137.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,510,200.00	38,827,400.00
210201	Тэтгэврийн даатгал	26,656,800.00	27,323,598.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,036,900.00	2,875,775.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,342,100.00	2,300,720.37
210204	Ажилгүйдлийн даатгал	497,700.00	575,255.07
210205	Эрүүл мэндийн даатгал	4,976,700.00	5,752,050.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,350,498.36	19,294,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,838,400.00	2,855,695.00
210302	Түлш, халаалт	12,067,825.11	14,210,303.00
210303	Цэвэр, бохир ус	3,444,273.25	2,228,002.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,619,431.40	6,112,622.92
210401	Бичиг хэрэг	1,699,160.00	1,406,982.00
210402	Тээвэр, шатахуун	306,400.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	670,000.00	659,558.00
210404	Ном, хэвлэл	373,003.20	75,742.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	196,668.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,570,868.20	3,623,672.92
2105	Нормативт зардал	44,562,460.00	41,299,905.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	261,100.00	10,744,100.00
210502	Хоол, хүнс	32,181,360.00	20,215,935.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,120,000.00	10,339,870.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,217,657.00	8,187,920.00
210604	Урсгал засвар	15,217,657.00	8,187,920.00

Хүүхдийн 8-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	96,400.00	117,000.00
210702	Дотоод албан томилолт	96,400.00	117,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,239,400.00	6,921,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,989,400.00	6,921,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,955,780.30	23,813,108.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,228,700.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,057,940.00	508,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,669,140.30	23,304,208.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	213,401.64	3,258,115.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	213,400.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	213,400.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1.64	3,058,115.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1.64	3,058,115.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-12,884,628.70	-9,570,278.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	859,375.22
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	859,375.22
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-12,884,628.70	-10,429,653.92

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,921,047.43	87,742,745.01	4,548,247.98	449,212,040.42
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	356,921,047.43	87,742,745.01	4,548,247.98	449,212,040.42
3	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,921,047.43	87,742,745.01	-8,336,380.72	436,327,411.72
4	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	356,921,047.43	87,742,745.01	-8,336,380.72	436,327,411.72
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	356,921,047.43	87,742,745.01	-8,336,380.72	436,327,411.72
6	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-10,429,653.92	-10,429,653.92
7	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	356,921,047.43	87,742,745.01	-18,766,034.64	425,897,757.80

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	220.451.100.00	425,889,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	425,889,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	425,321,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10.562.900.00	26,354,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00	393.200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	245,000.00	175.000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,954,200.00	26.354.500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,954,200.00	26.354.500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	206.830.580.25	414,689,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206.830.580.25	414,689,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206.830.580.25	411,431,285.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	151.239.147.76	292,408,200.00
210101	Үндсэн цалин	121.695.528.00	214,548,179.00
210102	Нэмэгдэл	15.712.567.00	43,277,375.00
210104	Урамшуулал	13.831.052.00	34,582,646.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22.016.900.00	38,827,400.00
210201	Тэтгэврийн даатгал	15.493.500.00	27,323,598.24
210202	Тэтгэмжийн даатгал	1.631.000.00	2,875,775.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1.304.700.00	2,300,720.37
210204	Ажилгүйдлийн даатгал	326.100.00	575,255.07
210205	Эрүүл мэндийн даатгал	3.261.600.00	5,752,050.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10.562.542.49	18,334,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1.821.508.15	3,668,795.00
210302	Түлш, халаалт	4.781.300.00	9,862,103.00
210303	Цэвэр, бохир ус	3.959.734.34	4,803,102.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1.301.000.00	3,332,300.00
210401	Бичиг хэрэг	297.000.00	406,532.00
210402	Тээвэр, шатахуун	20.000.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	450.000.00	659,558.00
210404	Ном, хэвлэл	14.800.00	75,742.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	184,068.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	519.200.00	1,856,400.00
2105	Нормативт зардал	20.458.890.00	41,562,285.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13.600.00	10,654,100.00
210502	Хоол, хүнс	9.315.290.00	20,268,885.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11.130.000.00	10,639,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	8,020,500.00
210604	Урсгал засвар	0.00	8,020,500.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	117,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	117,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	7,311,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	7,311,500.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,252,100.00	1,518,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	340,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	912,100.00	1,518,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,258,115.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1.64	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	3,058,115.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,058,115.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	150,000.00	11,200,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	150,000.00	11,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	150,000.00	11,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	150,000.00	11,200,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	150,000.00	11,200,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-150,000.00	-11,200,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	13,620,519.75	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,620,519.75	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	425,321,200.00	422,263,085.00	3,058,115.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	425,321,200.00	422,263,085.00	3,058,115.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425,121,200.00	422,063,085.00	3,058,115.00	99.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,408,200.00	292,408,200.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	218,068,300.00	214,548,179.00	3,520,121.00	98.39
210102	Нэмэгдэл	47,133,500.00	43,277,375.00	3,856,125.00	91.82
210104	Урамшуулал	27,206,400.00	34,582,646.00	-7,376,246.00	127.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,827,400.00	38,827,400.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	27,354,600.00	27,323,598.24	31,001.76	99.89
210202	Тэтгэмжийн даатгал	2,868,200.00	2,875,775.44	-7,575.44	100.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,294,600.00	2,300,720.37	-6,120.37	100.27
210204	Ажилгүйдлийн даатгал	573,600.00	575,255.07	-1,655.07	100.29
210205	Эрүүл мэндийн даатгал	5,736,400.00	5,752,050.88	-15,650.88	100.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,334,000.00	18,334,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	3,417,000.00	3,668,795.00	-251,795.00	107.37
210302	Түлш, халаалт	8,177,000.00	9,862,103.00	-1,685,103.00	120.61
210303	Цэвэр, бохир ус	6,740,000.00	4,803,102.00	1,936,898.00	71.26
2104	Хангамж, бараа материалын зардал	3,192,300.00	3,192,300.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	199,500.00	266,532.00	-67,032.00	133.60
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	150,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	663,000.00	659,558.00	3,442.00	99.48
210404	Ном, хэвлэл	72,300.00	75,742.00	-3,442.00	104.76
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	251,100.00	184,068.00	67,032.00	73.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,856,400.00	1,856,400.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	44,192,200.00	41,134,085.00	3,058,115.00	93.08
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,225,900.00	10,225,900.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	23,327,000.00	20,268,885.00	3,058,115.00	86.89
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,639,300.00	10,639,300.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,220,500.00	15,220,500.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,200,000.00	7,200,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	8,020,500.00	8,020,500.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	117,000.00	117,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	117,000.00	117,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,311,500.00	7,311,500.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,311,500.00	7,311,500.00	0.00	100.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,518,100.00	5,518,100.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,518,100.00	5,518,100.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	200,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	200,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	425,321,200.00	422,263,085.00	3,058,115.00	99.28
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	398,966,700.00	395,908,585.00	3,058,115.00	99.23
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	398,966,700.00	395,908,585.00	3,058,115.00	99.23
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,354,500.00	26,354,500.00	0.00	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	26,354,500.00	26,354,500.00	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	9	9	0.00	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	180	180	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	568.200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	568.200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	568.200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	140.000.00
210401	Бичиг хэрэг	140.000.00
2105	Нормативт зардал	428.200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	428.200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	393.200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	175.000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын хүүхдийн 8-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Цэцэгдулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын хүүхдийн 8-р цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэбулган сумын хүүхдийн 8-р цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харъяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгуулга юм.

Эрдэнэбулган сумын хүүхдийн 8-р цэцэрлэг нь “Хүүхдийн Эрүүл аюулгүй байдалд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан танхим болон цахимаар хичээллэх боломж нөхцлийг хангаж, сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, ажлын хариуцлага ёс зүй, хууль дүрмийг баримтлан зөв харилцаатай шударга ажиллах” гэсэн зорилготой үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 425.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 2.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	хувь
Бараа материал	29.7	27.5	(2.3)	(7.7)
Үндсэн хөрөнгө	406.6	398.4	(8.2)	(2.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>436.3</b>	<b>425.8</b>	(10.5)	(2.4)
Өр төлбөр	-	0	-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	436.3	425.8	(10.5)	(2.4)

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	436.3	425.8	(10.5)	(2.4)
--	-------	-------	--------	-------

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал эхний үлдэгдлээс -7.7 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын данс нь 29.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 69.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 70.0 сая төгрөг, акталсан 1.3 сая төгрөгөөр тус тус хасагдаж, эцсийн үлдэгдэл 27.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл -2.4 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 406.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 11.2 сая төгрөг, хандиваар 4.8 сая төгрөгөөр нэмэгдэж, акталж устгасан 0.9 сая төгрөг, тайлант хугацаанд байгуулсан 23.3 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 398.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл тайлант хугацаанд 10.5 сая төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрсөн байна.

#### Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17.6	4.8	(12.8)
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	367.3	398.9	31.6
Нэмэлт санхүүжилт	0.8	0.6	(0.2)
Орон нутгийн төсвөөс	25.0	26.3	1.3
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>410.7</b>	<b>430.6</b>	<b>19.9</b>
Цалин, шимтгэлийн зардал	311.3	331.2	19.9
Бараа ажил үйлчилгээний зардал	86.0	75.0	(11.0)
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2.2	6.9	4.7
Бараа үйлчилгээний бусад зардал	23.9	23.8	(0.1)
Урсгал шилжүүлэг	0.2	3.3	3.1
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>423.6</b>	<b>440.2</b>	<b>16.6</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(12.8)</b>	<b>(10.5)</b>	<b>2.3</b>

Хүүхдийн 8-р цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны үр дүн өмнөх оноос 19.9 сая төгрөгөөр өссөн нь тогтмол зардал өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 511.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 83.6 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 427.8 сая төгрөгөөр хянаж баталжээ. Тайлант жилд батлагдсан төсвийн хуваарьт 2 удаа тодотгол хийгдэж цалин, нормативт, тогтмол зардлуудыг бууруулан 425.3 сая төгрөг болсон байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 425.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр санхүүжилтээ бүрэн авч 422.2 сая төгрөгийг зарцуулж 3.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Төвлөрүүлэх шилжүүлэг нь хүүхдийн хоолны зардал болон бусад урсгал зардлаас хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Боловсролын газраас ариутгал халдваргүйжүүлэлт, бичиг хэргийн зардалд 0.3 сая төгрөг, тендерийн орлогоос 0.1 сая төгрөг нийт 0.5 сая төгрөгийг ариутгал халдваргүйжүүлэлт, бичиг хэргийн зардал зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Аудитын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант жилд ковид-19 цар тахалын улмаас хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа бүрэн явагдаагүй бөгөөд 4 сар үйл ажиллагаа явуулж хоолны зардалд 20.2 сая төгрөгийг зарцуулж, анх батлагдсан төсвөөс 54.7 сая төгрөг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тус цэцэрлэгийн барилгын ашиглалтын байдалд Архангай аймгийн МХГ-ын 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 03-07-022/42 тоот улсын байцаагчийн дүгнэлт гарч 2022 оны 02 сарын 13-нд БШУЯ-ны хөрөнгө оруулалтын газрын дарга, мэргэжилтэнгүүд ирж үзэн хүүхэд авах ямарч боломжгүй учир авч болохгүй гэсэн үүрэг чиглэл өгсөн байна. Үүний дагуу тус цэцэрлэгийг “Хүүхдийн сэргэлэн” цэцэрлэгийн байранд нүүлгэн шилжүүлж түрээс болон тогтмол зардлыг төлж үйл ажиллагаагаа явуулж байна. Цэцэрлэг нь гал тогоондоо гал түлж үйл ажиллагаагаа явуулж байгаа учир тогтмол зардал хүрэлцэхгүй цаашид өр үүсэж болзошгүй байгаа талаар цэцэрлэгийн эрхлэгчийн ирүүлсэн тайбарт бичсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 10 үндсэн зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 425.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.3 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд нормативт зардалд 3.0 сая төгрөгийн хэмнэлт гаргаж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хүүхдийн 8-р цэцэрлэг нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 138 мэдээллээс 135 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант жилд нормативт зардалд 3.0 сая төгрөгийн хэмнэлт гаргаж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт нийцэж байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Хүүхдийн 8-р цэцэрлэгийн 2021 оны 3-р улирлын санхүүгийн баримт завсрын аудитад хамрагдсан бөгөөд завсрын аудитаар нийт 12.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж 2021.12.28-ны өдрийн 135 тоот албан бичгээр биелэлтийг хангуулан ажилласан байна.

### **3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

Хүүхдийн хоолны зардалд норм тооцож байгаа эсэхийг тулган шалгах

## **4. Аудитын илрүүлэлт**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9.4 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 1 заалт зөвлөмж хүргүүлээ.

### **4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт: Улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгохдоо ажилчдад ижил хувиар хавтгайруулан олгосон.

Өгсөн зөвлөмж: Иймд ЗГ-ын 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу үнэлж урамшуулдаг байх зөвлөмж хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хүүхдийн 8-р цэцэрлэг	1	0							1	0
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Хүүхдийн 8-р цэцэрлэг	1	0							1	0
<b>НИЙТ ДҮН</b>		<b>2</b>	<b>0</b>							<b>2</b>	<b>0</b>

----oO-----